



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/252

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 23/14 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 7 дугаарт батлагдсан Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдаж авах зардлаас Тарагт сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах зардалд 85,000,000 (наян таван сая) төгрөг, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах зардалд 85,000,000 (наян таван сая) төгрөг, нийт 170,000,000 (нэг зуун далан сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газарт даалгасугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

624 11 0514